

ОРХОН АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
НАМХАЙ ОВОГТОЙ САНДУЙГИЙН СОНГУУЛИЙН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Сонгуулийн уриа: Дэвшилтэд технологийг орон нутагтаа.


Энэхүү мөрийн хөтөлбөр нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон бусад эрх зүйн актуудын хүрээнд боловсруулагдсан ба хэрвээ ИТХ-д сонгогдсон тохиолдолд төлөөлөгчийн хувьд Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх зорилтот ажлууд мөн тухайн нэр дэвшигчийн нэр дэвших баг дээр хийж хэрэгжүүлэх, шийдвэрлэх зорилтуудыг 2 хэсэгт багтаан томъёолж өгсөн болно.

Зорилт 1. Эрдэнэт хотын хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд.

- 1.1. Хүн ам, ялангуяа эх хүүхэд, эмзэг бүлгийн хүмүүст хүрэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хамралтыг сайжруулах.
- 1.2. Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэх, ашиглахад саад болж буй газар зүйн байршил, санхүүгийн бэрхшээлийг багасгах.
- 1.3. БОЭТ-ийг түшиглэж хүчирхийлэлийн эсрэг төвийг байгуулж үйл ажиллагааг тогтворжуулах, хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийн боловсролд анхаарал тавьж цаашид суралцах нөхцлийг хангаж ажиллана.
- 1.4. Үндэсний хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг уялдуулан ажилласнаар баг, сум, өрхийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулхад үе шаттай бодлого боловсруулж ажиллана.
- 1.5. Түргэн тусламжийн үйлчилгээг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж тоног төхөөрөмж, автомашинаар хангаж, засвар үйлчилгээг тогтмолжуулна.
- 1.6. Өдрийн болон гэрээр үзүүлэх батлагдсан тусламж, үйлчилгээг хүргэхэд шаардлагатай эмнэл зүйн стандарт удирдамжийг мөрдөх талаар эрүүл мэндийн ажилтануудад зориулан сургалт зохион байгуулах.
- 1.7. Орхон аймгийн хүн амд сүүлийн үеийн дэвшилтэд технологи болох үе мөч болон дурангийн хагалгааг хүртээмж чанартай хүргэх тал дээр анхаарч ажиллана.

Зорилт 2. Багийн хэмжээнд хийж хэрэгжүүлэх ажлууд.

- 2.1. Хүүхэд тоглох тоглоомын тамбайг засварлах, унаж гэмтэхээс сэргийлэн зориулалтын зөөлөвчин хиймэл зүлгээр засварлан аюулгүй байдлыг хангахад анхааран ажиллана.
- 2.2. Багийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настны хөгжлийн төв, хүүхэд залуусын чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх ногоон байгууламж, биеийн тамир



спортыг хөгжүүлэх цогцолбор, гэр бүлээрээ цагийг өнгөрүүлэх монгол ахуй өв соёлын төвүүдийг байгуулах, үйл ажиллагааг нь тогтворжуулан ажиллана.

2.3. Багийн нутаг дэвсгэрт харьяалагдах сургууль, цэцэрлэг, ерхийн эрүүл мэндийн төвийн хүртээмжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллана.

2.4.

Зорилтод бүлгийн хүн амд болон ахмад настан, харж хандах хүнгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандуулах нийгмийн бүхий л дэмжлэгийг жигд хүртээлмжэй хүргэхэд онцгой анхаарч ажиллана.

Мөрийн хөтөлбөрийг боловсруулсан  Н.Сандуй



2020.07.24.

